



Христийн Бие **Израилд залгагдсан мөчир мөн үү?** **Чидун модны тухай Паулын** **сургаалт зүйрлэлийн тайлал**

Олон итгэгч чидун модны тухай Паулын үгийг уншаад өөрийгөө “Есүст итгэхдээ Израилд¹ хамрагдсан” гэсэн ойлголтыг авсан. “Христийн Бие нь Чидун мод болох Израилд залгагдсан мөчир” гэж тэд үзнэ. Паулын сургаалт зүйрлэл өөр утгатай гэдгийг уг судалгаа харуулна.

Юуны өмнө «Ром» захидлаас олох тухайн хэсгийг хамтдаа уншъя. Үүнд:

“Харийнхан [грек: **үндэстнүүд**] та нарт би хэлье... үндэс хэрэв ариун бол мөчрүүд ч бас тийм байна. Хэрэв хэсэг мөчир таслагдаад, оронд нь зэрлэг чидун болох та, тэдний дунд залгагдаж, чидун модны үндэсний шимээс хүртэгч болсон бол, өнөөх мөчрүүдийн эсрэг бүү сайрх. Хэрэв сайрхмаар бол та үндсийг биш, харин үндэс таныг тэтгэж байгааг санагтун. Тэгвэл та "Намайг модонд залгахын тулд тэр мөчрүүд таслагдсан шүү дээ" гэж хэлнэ. Тийм ээ, тэд итгэлгүйдээ таслагдсан бол та итгэлээрээ [грек: итгэлээр] зогсож байна. Бүү дээгүүр санаарх, харин эмээ. Хэрэв Бурхан төрөлх мөчрүүдийг хэлтрүүлээгүй бол таныг ч гэсэн хэлтрүүлэхгүй.



1 “Израил” гэдэг нь Библид Абрахам, Исаак, Яаков нараас үүссэн 12 овогтой үндэстэнг хэлдэг болохоос өнөөгийн, Ертөнцийн Эзэнд итгэдэггүй төрийг хэлээгүйг анхаарна уу.



Тиймээс Бурханы энэрэл хийгээд хатуурхлыг харагтун. Унагсад дээр хатуурхал байдаг тул Бурханы энэрэлд үлдвээс тан дээр энэрэл оршино. Эс бөгөөс та ч гэсэн таслагдана.

Түүнчлэн тэд итгэлгүй байдалдаа эс үлдвээс залгагдах болно. Учир нь Бурхан тэднийг дахин залгах чадалтай. Хэрэв та төрөлхийн зэрлэг модноос таслагдаад тэр чанарынхаа эсрэг таримал чидун модонд залгагдсан юм бол, төрөлх нь төрөлх модондоо тэр тусмаа залгагдах биш үү?” (Ром 11:13-24, АБ2019)

Юуны өмнө эндээс анзаарахад, тус модонд залгагдсан мөчир нь хэрэв ямар нэгэн буруу юм хийвэл Ертөнцийн Эзэний “хатуурлыг үзэн” тэр “модноос таслагдах” аюултай. Энэ нь авралаа алдахыг хэлдэг гэж ойлгох нь түгээмэл. Ямартай ч, “Авралаа алдаад буцаж залгагдаж болох уу?” зэрэг асуултыг хүмүүс тавьдаг.

Үүнээс харахад өөрийгөө Израилын модонд залгагдсан мөчир гэж ойлгодог итгэгч хүн авралаа алдахаас айж явахад хүрнэ. Ертөнцийн Эзэн бидэнд айдсын сүнсийг өгөөгүй учраас энэ нь ноцтой асуудал (2 Тимот 1:7). Улмаар, энэ айдас нь тэр хүнийг Их Эзэний «Ром» захидалд бичүүлсэн бусад үгэнд нь итгэж чадахгүйд хүрэх нь бүр ч ноцтой асуудал юм!

Хатуу шийтгэлээс эмээж явахыг сануулсан энэ сургаалт зүйрлэлийн өнгө аяс, утга учир Паулын өмнө нь бичсэн олон үгтэй огт нийцэхгүйг анзаарууштай. Тухайлбал:

--“Бид Түүний нигүүлслээр үнэгүй зөвтгөгдсөн!”

--“Итгэлээр зөвтгөгдсөн бид ... Бурхантай эвлэрсэн билээ.”

--“...хэрэв бид дайснууд байхдаа Хүүгийнх нь үхлээр Бурхантай эвлэрүүлэгдсэн юм бол, тэр тусмаа бид Түүний амиар аврагдах болно.”

--“Христ Есүс дотор байгаа хүмүүст ямар ч ял байхгүй!”



- “Дахин айдаст хүргэх боолчлолын сүнсийг та нар хүлээн аваагүй, харин үрчлэлийн Сүнсийг авсан билээ. Түүгээр бид "Аав! Эцэг минь!" гэж дууддаг...”
- “Биднийг Бурханы хүүхдүүд гэдгийг Сүнс Өөрөө бидний сүнстэй хамт гэрчилдэг.”
- “...өнөө үеийн зовлонгууд нь бидэнд илчлэгдэх тэрхүү алдартай зүйрлүүлшгүй...”
- “Бурханы хайраас биднийг юу ч салгаж чадахгүй!”
(Ром 3:24; 5:1,10; 8:1,15-16,18,39)

Эдгээр үлэмжийн их үнэ цэнэтэй үгийг та нэг нэгээр нь авч үзээд, “хэрэв авралаа алдах нь боломжтой юм бол энэ үг хэр баталгаатай вэ? Би тэр үгэнд бүрэн итгэж чадах уу?” гэж өөрөөсөө асуугаарай. Жишээ нь, “Христ Есүс дотор байгаа хүмүүст ямар ч ял байхгүй” гэж уншаад, “хэрэв итгэгч хүн “модноос таслагдах” боломжтой юм бол итгэгч хүнд үнэхээр ямар ч ял байхгүй гэж үү?” гэж асууж үзээрэй.

Нэгэнт “модноос таслагдах” нь ямар нэгэн ялыг хэлэх нь тодорхой учраас энд зөрчил байх нь илэрхий. Итгэгч бидэнд нэг бол “ямар ч ял байхгүй” (Ром 8:1), өөрөөр хэлбэл “модноос таслагдах” аюул бидэнд хамаагүй – эсвэл бид тийм ялыг авах боломжтой бөгөөд Ром 8:1 утгагүй хоосон үг болж хоцорно. Гэтэл Их Эзэний үг хоосон байна гэж байхгүй нь мэдээж. Энэ аюул бидэнд байхгүй гэсэн үг.

Мөн энэ хоёрыг “дэнслэн үзээд тэнцвэржүүлэх” арга үйлчлэхгүй. Нэг бол ял байгаа – нэг бол ял байхгүй. Жаахан ялтай, жаахан ялгүй гэдэг нь “жаахан жирэмсэн, жаахан жирэмсэн биш” эмэгтэй шиг. Тийм утгагүй юм мэдээж байхгүй. Зөвхөн нэг л тал таны хувьд үнэн байх боломжтой. Тэгвэл ганц үлдсэн асуулт: та аль үгийг өөртөө хамаатай гэж хүлээн авах вэ?



Итгэгчийн байдлыг тов тодорхой хэлсэн Ром 8-ын тэр үгэнд үү?

Эсвэл Ром 11-т буй, утга нь бүрхэгдүү сургаалт зүйрлэлийг өөртөө наалдуулах нь танд илүү санагдах уу?

Энэ шийдвэрийг гаргахад тэр сургаалт зүйрлэлийн бүрхэг утгыг тайлан ойлгох шаардлага бидэнд бий. Улмаар, бидэнд зориулж бичүүлсэн Их Эзэнийхээ бүх үгийг бид илүү сайн ойлгохыг хүсдэг учраас утгыг нь авч үзье.

Чидун мод “хорвоогийн гэрэл”-ийг цацруулдаг

Юуны өмнө хэлэхэд, “чидун мод Израилыг билэгддэг” гэж хэлэх нь дутуухан ойлголт өгөх юм. Израилыг билэгдэх гурван янзын мод бий. Үүнд: Усан үзмийн мод, инжрийн мод, чидун мод. Энэ гурав Израилын гурван талыг билэгдэнэ. Усан үзмийн мод Израилын авчрах баяр хөөрийг билэгдэх бол, инжир мод нь тэдний Их Эзэнээс хүртэн авч энэ дэлхийд түгээх зөв шударга байдлыг билэгдэнэ.





Харин чидун мод
Ертөнцийн Эзэний
илчлэлийн гэрлийг
үндэстнүүдэд
цацран туяарах
Израилын үүрэг ба
давуу эрхийг
билэгдэнэ.



Чидун модны
тосоор майхан

сүмийг гэрэлтүүлдэг байсан болохоор чидун нь Ертөнцийн Эзэний өгдөг гэгээрлийн эх үүсвэрийг билэгддэг юм. (Энэ холбоог мөн Зехариа 4:2-3-с хараарай.)

Тос нь “зүрхний мэлмийг гийгүүлэх”, Ертөнцийн Эзэний “мэргэн ухаан хийгээд илчлэлийн Сүнсийг” билэгддэг (Эфэс 1:17-18). Харин түүнээс гарах гэрэл нь Ертөнцийн Эзэний зам заах зөгнөл ба амлалт бүхий үгийг билэгдэнэ (Дуулал 119:105; Галат 3:14; 2 Петр 1:19).

Нарны гэрэл энэ дэлхийд өгсөн хамгийн том байгалийн нэг ивээл байхын адил Ертөнцийн Эзэний Үгийн гэрэл нь хүн төрөлхтөнд өгсөн хамгийн том сүнслэг ивээлийн нэг билээ. Чидун мод нэг ёсондоо “хорвоогийн гэрэл” байх Израилын дуудлагын билэг тэмдэг юм (Матай 5:14).

Их Эзэн үндэстнүүдийг Израилын “инжрийн мод”-онд ч залгаагүй, “усан үзмийн мод”-онд ч оруулаагүй нь учиртай. Инжрийн модны дүрсэлсэн энэ дэлхийн шударга зөв засаглал хэзээ ч өөр үндэстэнд шилжээгүй. Энх тайвны Хаан болох Израилын Машиахгүйгээр зөв шударгын засаглал байгуулах боломжгүй. Үндэстнүүд мөн Израилын мянган жилт Хаант улсын үүсгэн тэтгэх баяр хөөрийг энэ дэлхийд авчирч чадахгүй. Чидун модны дүрсэлсэн тэр ганц давуу эрхийг л Ертөнцийн Эзэн үндэстнүүдэд өгчээ.



Илчлэлтийн гэрэл нь Израил үндэстнийг орхиж, бусад үндэстнүүдийн дунд оршдог болсон. Өнөөдөөр Ертөнцийн Эзэнийг энэ дэлхийд гэрчлэх гэрч нар нь үндэстнүүдийн дунд гэрэлтдэг юм.

Одоо «Ром» захидлын 11-р бүлгээс чидун модны тухай Паулын сургаалт зүйрлэлийг хэсэг хэсгээр нь авч үзье.

Энэ зүйрлэл ХЭНД хамаатай вэ?

Юуны өмнө анзаарахад, Их Эзэн Паулаар дамжуулсан эдгээр үгсийг хувь хүмүүст биш, “үндэстнүүдэд” хандан бичсэн байна (13-р иш). “Үндэстнүүд” гэсэн үг энэ бүлгийн грек эхэнд таван удаа, үргэлж олон тоогоор гардаг.

“Израил” мөн адил таван удаа дурдагдсан. “Дэлхий” хоёр удаа гарна. Харин “итгэгч”, “Христийн бие”, “ариун хүн”, “Христ” хүртэл энэ бүлэгт нэг ч дурдагдаагүй. Энэ бүлэг итгэгчдийн тухай биш, харин Израил ба үндэстнүүдийг дэлхийн хэмжээнд авч үзсэн.

«Ром» захидлын бүтцийг мэдэх нь мөн тустай. Тус захидлын 5-8-р бүлэг хувь итгэгчийн байр суурийн тухай байхад 9-11-р бүлэг нь Израил ба үндэстнүүдийн тухай юм. 11-р бүлэгт байрласан энэ сургаалт зүйрлэл тэгвэл хувь хүнийг биш, үндэстнүүдийг авч үзэж байгаа нь батлагдаж байна. Харин **хувь хүний хүрээг үндэстний хүрээтэй хольж хутгаж болохгүй юм.**



Тус модны “төрөлх мөчрүүд” нь израил үндэстнийхэн болох нь маргаангүй биз ээ. Таслагдсан мөчрүүд нь Ертөнцийн Эзэний “хатууруулсан”, итгэлгүй израилчуудыг билэгдэнэ (7-р иш). Хуулийн зааснаар гэмийг “санаатайгаар үйлдэгч нь... ард олныхоо дундаас таслагдах болой. Тэр хүн *ЭЗЭНий үгийг* үл тоомсорлож, *Түүний тушаалыг* зөрчсөн тул тэр хүн



бүрмөсөн таслагдаж, хилэнц нь өөр дээр нь байна”
(Тооллого 15:30-31, мөн Үйлс 3:19-23-г үзнэ үү).²

Модондоо үлдсэн өөр зарим мөчир нь итгэлтэй, итгэмжит
израилчуудыг буюу “үлдэгсэд”-ыг хэлнэ (5-р иш).

Израилаас цөөн хүн л өнөөдөр Ертөнцийн Эзэний сүнсээр
гэгээрч, Түүний Үгийг олны өмнө өндөрт өргөдөг
(зүйрлэвээс, хэдхэн төрөлхийн мөчир модондоо үлдсэн).

Чидун модны үндэс нь Израилын өвөг эцгүүдийг билэгдэнэ
(гол иш нь үндэсний хэсэгт тооцогддог; Исаиа 53:3).

Модны үндэс мөчрөөсөө өмнө бий болдог бөгөөд мөчрүүд
нь үндэснээс салбарлан ургадаг билээ. Мөчир гишүүд
үндэстэйгээ салшгүй холбоотой.

-
- 2 Тухайн үеийн иудейчүүдийн хийсэн хамгаас аймшигтай гэм нь Машиах Аврагчаа алсан явдал юм. “Түүнийг цовдол” гэж хашгиралдахдаа иудейчүүд “юу хийж байгаагаа мэдэхгүй” байсныг Есүс хэлсэн (Лук 23:34). Иймд Есүсийг тэнгэр одсоны дараа Их Эзэн тэдэнд апостол элч нараа илгээж, Есүсийн талаар бодол явдлаа өөрчлөх дахиад нэг боломж олгожээ. Есүс Ертөнцийн Эзэний томилон илгээсэн Машиах болохыг Петр иудейчүүдэд Ариун Сүнсний хүчээр сайтар тунхагласан. Улмаар, “Ариун агаад зөвт Нэгэнийг та нар үгүйсгэсэн атлаа алуурчныг хэлтрүүлэхийг гуйж, амийн Эхлүүлэгчийг алсан. Харин Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулан босгосон бөгөөд үүний гэрч нь бид юм... Мосе хэлэхдээ “Миний адил эш үзүүлэгчийг Эзэн Бурхан ах дүү нараас чинь та нарт гаргаж ирнэ. Түүний өөрсдөд чинь хэлэх юм бүрийг та нар сонсогтун. Тэр эш үзүүлэгчийг сонсоогүй хэн боловч ард олны дотроос бүрмөсөн **устгагдах** болно” гэсэн юм. Мөн Самуел болон түүнээс хойших эш үзүүлэгчид бүгд ярихдаа энэ өдрүүдийн тухай мэдэгдэж байсан. Та нар бол эш үзүүлэгчдийн хөвгүүд бөгөөд “Чиний үрээр дэлхийн бүх өрх айлууд ерөөгдөх болно” хэмээн Абрахамд айлдан, эцэг өвгөдтэй чинь Бурханы байгуулсан гэрээний хөвгүүд юм. Та нарын хүн нэг бүрийг хорон муу замаас нь эргүүлснээр ерөөхийн тулд Бурхан эхлээд та нарт Өөрийн зарцыг гаргаж ирэн, Түүнийг илгээсэн юм” хэмээн тэднийг хатуу үгээр эрс шулуун буруутган зарлагуудын үгийг сануулж Есүст итгэхээр ятгасан (Үйлс 2-3, 3:14-15, 22-26; АБ2019). Үүнээс хойш иудейчүүд юу хийснээ сайн мэдсэн бөгөөд тэр аймшигт буруу замаасаа эргээгүй хүн ямар ч хүлцэл хүлээх хэрэггүй болжээ.



Үүнчлэн өвөг эцгүүд нь израил үндэстний өмнө орших бөгөөд өөрөөс нь урган гарсан үндэстэнтэй салшгүй холбоотой юм. Энэ тайллыг хам сэдвийн хүрээ нь дэмждэг. Паул 9-р бүлгээс эхлэн Абрахам, Исаак, Иаков нарын тухай бичиж ирсэн байна.

Тэрхүү “ариун үндэс”-ний ачаар мөчрүүд, тэр дундаа таслагдсан мөчрүүд нь хүртэл ариунд тооцогддог (16-р иш). “Ариун” гэдэг нь Бичвэрүүдэд “тусгай зориулалттай” гэсэн утгатай билээ.

Үүнчлэн Паул итгэлгүй дайсагнах израилчуудыг хүртэл “эцгүүдийнхээ учир хайрлагдагсад” мөн гэдгийг баталдаг (28-р иш). Гэтэл чидун модны үндэстэй төрөлхийн холбоогүй зэрлэг модны мөчрийг Паул хаана ч “ариун” гэж хэлээгүй. Үүнчлэн үндэстнүүдийг “эцгүүдээс болж хайрлагдсан” гэж хэлдэггүй. Үндэстнүүд Израилын өвөг дээдэстэй гарал үүслийн, ураг төрлийн ямар ч холбоогүй учраас тэр.



Тэгсэн ч гэсэн Ертөнцийн Эзэн зэрлэг модны мөчир мэт үндэстнүүдийг “чидун мод”-ондоо шигтгэсэн. Их Эзэн Өөрийнхөө тухай мэдлэгийг өнөөдөр дэлхийд түгээн, Өөртөө хүндлэл авчрахаар бусад үндэстнүүдийг ашиглаж



байна. Өнөөдөр Ертөнцийн Эзэний Үгийг хэн хэвлэж, зарж, үнэгүй тарааж, орчуулж, судалж, зааж, түгээж байгааг бодоорой.



Гэтэл зэрлэг модны мөчир нь таримал модонд залгагдсаныхаа ачаар тус модны шим шүүсийг авах боловч төрөлхийн модондоо байхдаа ургуулдаг байсан тэр л навч, жимсийг ургуулдаг хэвээр байдгийг хөдөө аж ахуй заадаг.

Зэрлэг модны мөчир гишүү өөрийн төрөлх чанараа алддаггүй гэсэн үг. Хэзээ ч залгагдсан модныхоо үндэстэй генийн түвшинд нэгдэхгүй. **Тэгэхээр “Израилд залгагдсан үндэстний хүмүүс израилчууд болдог” гэж ойлгох нь лав буруу.**

Чидун модны шим шүүсний баялаг: зөвтгөл ба эвлэрэл

Таримал чидун модны үндсээс дээш гарч мөчрүүдийг

тэжээдэг шим шүүс (грек: тос) чидуны баялгыг илэрхийлнэ. Шим шүүс нь өвөг эцгүүдэд өгсөн Ертөнцийн Эзэний амлалтын үгс ба тэр амлалтаас урсан гарах ивээлийг билэгдэх юм. Төрөлх мөчрүүдийн “дунд залгагдсан” зэрлэг мөчир “чидун модны үндэсний шимээс хүртэгч болсон” нь Ертөнцийн Эзэн



үндэстнүүдийг бүхлээр нь Израилын өвөг дээдэст өгсөн ивээлээс шууд хүртэх байр сууринд оруулсныг хэлнэ.

Өөрөөр хэлбэл, үндэстнүүд израилчуудын зуучлалгүйгээр Ертөнцийн Эзэний илчлэлтийг шууд авах боломжтой болсон.

Энэ бол израилчуудын хувьд төсөөлшгүй хэрэг байлаа.

Бүх зөгнөлийн дагуу бусад үндэстнүүд зөвхөн Израилаар дамжин ивээгдэх ёстой юм. Ертөнцийн Эзэн эхнээс нь Абрахамын удмаар дамжуулан бүх үндэстнүүдийг ивээхээр амласан бөгөөд энэ амлалтыг Исаак, Иаков нарт давтаж өгсөн билээ (Эхлэл 22:18; 26:4; 28:14).



Гэвч Израил нэгэнт үндэстний хэмжээнд Есүс Их Эзэнээс татгалзсан тул үндэстнүүдийг ивээх тэдний “суваг” нэг ёсондоо “бөглөрчээ”. Үүнд Ертөнцийн Эзэн үндэстнүүдийг шууд ивээдэг болсон. Паулын үйлчлэлээс эхлэн Израилын “алдаа зөрчил нь дэлхийн баялаг” болжээ (12-р иш). Үндэстнүүд шууд л Израилын өвөг дээдэст өгсөн амлалтын ивээлд залгагдах болохыг итгэлтэй, итгэлгүй ямар иудей хүн төсөөлсөнгүй.

Дэлхийд ирсэн тэр ивээлийн баялгийг нарийн авч үзье. Абрахамын ивээл ерөөл үндэстнүүдэд шууд ирсэн талаар Паул галатчуудад тодорхой бичсэн. Тухайлбал:

“Та нарыг Сүнсээр хангаж, та нарын дунд гайхамшигийг үйлддэг Тэрээр үүнийг хуулийн үйлсээр үйлддэг үү, эсвэл сонссондоо итгэснээр чинь үйлддэг үү?



Яг үүнчлэн Абрахам “Бурханд итгэсэн бөгөөд үүгээр нь түүнийг зөвд тооцсон” юм. Тиймээс итгэлийн хүмүүс нь Абрахамын хөвгүүд юм гэдгийг мэдэж ав. Бурхан харийнхныг [грек: үндэстнүүдийг] итгэлээр зөвтгөнө гэдгийг Бичвэр

урьдаас мэдээд “Бүх үндэстэн чамаар ерөөгдөх болно” гэж Абрахамд сайнмэдээг урьдчилан тунхаглажээ (Эхлэл 12:3, 18:18). Тиймээс итгэлийнхэн нь итгэлийн хүн Абрахамын хамт ерөөгдсөн аж...

Учир нь, “Зөвт хүн итгэлээр амьдарна”... Ингэснээр Христ Есүс дотор Абрахамын ерөөлийг харийнханд [грек: үндэстнүүдэд] ирүүлэх юм. Ингэснээр бид амлагдсан Сүнсийг итгэлээр хүлээн авна.” (Галат 3:5-9, 12, 14; АБ2019)



Энэ гайхалтай үгнээс харахад Израилын өвөг эцэг Абрахамаас ирэх ивээлийн баялаг бол “итгэлээр зөвтгөгдөх”-өд орших юм. Шүүхийн гэм буруугүй гэж тогтоосон хүнийг “зөвтгөгдсөн” гэдэг – монголоор “цагаатгасан”. Паулын зарласан сайн мэдээнд итгэж, Христийн Биеийн гишүүн болсон хүн бүр Их Эзэний хувьд гэмгүй зөвд тооцогддог.

Энэ тухай Паул «Ром» захидлын 3-8-р бүлэгт дэлгэрэнгүй заасан. Үндэстнүүдээс гаралтай итгэгчид лав итгэлийн хувьд “Абрахамын хөвгүүд” болжээ. Энэ бол мэдээж ураг төрлийн хэлхээ биш, харин сүнслэг холбоо харилцаа. Израилын “алдаа зөрчлөөс болж” буй болсон энэ итгэлийн холбогдолын ачаар “үндэстнүүдэд аврал ирсэн” нь тэр (11-р иш). Итгэлээр зөвтгөгдөх нь үнэхээр аврал ба асар их баялаг мөн.

“Зөвтгөгдсөн” хүнийг Ертөнцийн Эзэн “урьдаас тогтоосон, мөн дуудсан”. Улмаар түүнийг “алдаршуулсан” гэсэн гайхалтай үгнэн бичигджээ (Ром 8:30). Одоохондоо ил алдаршуулагдсан итгэгч байхгүй ч гэсэн, ирээдүйд алдаршуулагдах нь дэндүү лавтай учраас Паул үүнийг “зөгнөлийн өнгөрсөн цаг”-аар бичсэн байна. Үүнээс ч харахад зөвтгөгдсөн хүн цагаатгалаа буюу Их Эзэний шийдээр авсан зөв шударга байдлаа алдах боломжгүй. Есүс Христийн итгэлээр цагаатгасан хүн магнай өндөр явж чадна.

Ертөнцийн Эзэнд шударга зөвд тооцогдох нь бидний авралын эхлэл. Цагаатгалын дагалдаагаар гарах зүйл бол Ертөнцийн Эзэнтэй эвлэрэх гайхамшигт явдал юм. Энэхүү эвлэрлийг Ром 11-т ч дурдсан. Тухайлбал: Израилын “огоорол нь дэлхийн эвлэрэл” юм (15-р иш). Коринтчуудад Паул энэ талаар бичихдээ:



“...Тэрээр биднийг Христээр дамжуулан Өөртэйгөө эвлэрүүлсэн. Ийнхүү эвлэрлийн үйлчлэлийг бидэнд өгчээ. Учир нь Бурхан дэлхийг Христ дотор Өөртэйгөө эвлэрүүлж, тэдний гэм бурууг эс тооцсон ба эвлэрлийн үгийг бидэнд даалгасан билээ. Иймээс бид Христийн төлөөх элчин сайд юм. Бурхан биднээр дамжуулан ятгаж байгаачлан Христийн төлөө та нараас бид гуйя. Бурхантай эвлэрцгээ. Нүглийг үл мэдэгч Түүнийг бидний төлөө Тэрээр нүгэл болгосны учир Түүний дотор бид Бурханы зөвт байдал болох юм.” (2 Коринт 5:18-21; АБ2019)

Сүүлчийн ишлэлд эвлэрлийн үндсийг бас дурдсан байна: гэм бурууг Есүс Христ авч хаясан учраас бид Ертөнцийн Эзэний зөв шударгыг хүртэх болсон. Энэхүү үндсэн дээр Ертөнцийн Эзэн бидэнтэй эвлэрсэн. Үүнд итгэсэн хүн Бүтээгч Эзэнтэй эвлэрнэ. Ингээд хоёр талаас эллэрэлдсэн байх нь хүний сэтгэл санаанаас эсвэл гаргадаг алдаанаас нь шалтгаалахгүй бодит харилцаа юм.




Өөрийг нь зөвтгөсөн, өөртэй нь сайндаж эвлэрсэн гэж хэлсэн Ер бусын Эцэгийнхээ үгэнд итгэсэн хүн өөрийн тэр итгэлээ хүртэл Их Эзэнээс ирсэн бэлэг гэж олж харна (Эфэс 2:8). Аврал нь өөрөөс нь болоогүй учраас авралаа алдах нь ч боломжгүй. Христийн хийсэн ажлын үндсэн дээр нэгэнт албан ёсоор цагаатгасан хүнийг эргээд ял шийтгэлд оруулна гэж байхгүй.



Нэгэнт эвлэрэлдэн, хувийн харилцаатай болсон хүнийг Тэрээр буцаагаад гэр бүлээсээ хөөхгүй. Ертөнцийн Эзэн хүмүүстэй сайндаад муудаад байдаг ааштай бурхан биш ээ. Түүний бэлгүүд буцалтгүй билээ (Ром 11:29). Юу ч биднийг Ертөнцийн Эзэний хайраас салгаж чадахгүй шүү дээ. “Юу ч” гэсэн үгэнд бүх юм – бид өөрсдөө бөгөөд бидний үе үе гаргадаг итгэлгүй байдал хүртэл – орно (Ром 8:30).

Ертөнцийн Эзэн ганцхан итгэгч хүнтэй биш, хамаг дэлхийтэй ч эвлэрсэн гэсэн гайхалтай үнэнийг дээрх ишлэл бидэнд илчилдэг. Үүнийг ч таримал модонд залгагдсан мөчир илэрхийлдэг. Ертөнцийн Эзэн хүн төрөлхтөнийг дайснаа гэж үзэхээ больж, харин ч тэдэнд Өөрийн хамгийн нандин бэлэг болох Үг, Илчлэлтээ чөлөөтэй өгсөн юм.



Гэхдээ үнэн эвлэрэлд нэг л тал сайндсан байх нь хангалтгүй. Тиймээс Паул үндэстнүүдэд “эвлэрлийн үгийг” зарлан, “Ертөнцийн Эзэнтэй эвлэрцгээ” гэж уриалдаг. “Одоо тааламжтай цаг. Харагтун, одоо авралын өдөр” гэж тэдэнд анхааруулжээ (2 Коринт 6:2). Энэ авралын хугацааг Паул чидун модны зүйрлэл бичихдээ ч бодсон юм. Тэр хугацаа яг хэзээ дуусахыг хэн ч мэдэхгүй. Гэтэл үндэстнүүдэд өгсөн “авралын өдөр” бусад өдрийн адил төгсөх нь гарцаагүй.

Зэрлэг мөчир ирээдүйд эргээд таслагдах нь лавтай Иймд, өнөө зэрлэг ганц мөчир хэзээ нэгэн цагт таримал модноос таслагдах нь лавтай. “Намайг модонд залгахын тулд тэр мөчрүүд таслагдсан шүү дээ” гэж тэр мөчрийг хэлэхэд Паул хариуд нь: “та итгэлээрээ [грек: итгэлээр!] зогсож байна. Бүү дээгүүр санаарх, харин эмээ.



Хэрэв Бурхан төрөлх мөчрүүдийг хэлтрүүлээгүй бол таныг ч гэсэн хэлтрүүлэхгүй” гэж анхааруулсан билээ (19-21-р иш). Төсөөлмөл энэ ярилцлагаар дамжин Паул тэр чухал үнэнг мөн адил илэрхийлдэг. Өнөө үед үндэстнүүд Израилын зуучлалгүйгээр, Их Эзэнтэй шууд харьцах давуу эрхтэй байр сууринд өргөмжлөгдсөн ч, энэ байдал мөнхөд үргэлжилнэ гэж ойлгож болохгүй. Төрөлхийн тэр зарим мөчир модноосоо таслагдсаны адил өнөө зэрлэг мөчир ч ирээдүйд эргээд тас татагдан оронд нь төрөлх мөчрүүд эргээд модондоо залгуулах нь лавтай.



Үндэстнүүдийг *ганц л* мөчир гишүүгээр дүрсэлж тэр мөчрийг “та” гэж ганц тоогоор л хандан ярьж байгааг анзаарсан уу?

Үндэстнүүдийг бүхлээр нь ганц мөчрөөр билэгдсэнээр Паул тэдний таримал модонд залгагдсан байдлыг маш тодорхой болгосон. Тэд нэг бол залгагдсан, нэг бол таслагдсан байдалтай. Зарим үндэстнүүдийг таслан авч, өөр заримыг нь таримал модонд залгаастай хэвээр үлдээнэ гэж байхгүй. Энэ нь тус сургаалт зүйрлэлийг хувь итгэгч хүмүүсийг авч үзээгүйн ахин нэг баталгаа.

Улмаар, үндэстнүүдийн өнөөдөр “зогсох”-од хүргэдэг зүйл бол итгэл билээ. Даан ч ихэнх хүмүүст үнэн итгэл алга. Тиймээс ч Паул үндэстнүүдэд “эмээ!” гэж анхааруулдаг. Грек эхэнд тэр итгэл хэнийх болох нь тодорхойгүй. Гэтэл “итгэлийн хүмүүс” хэн болох нь ойлгомжтой. Тухайлбал: Бүх үндэстнүүдийн дундаас Паулын зарласан сайн мэдээнд итгэсэн (ба ирээдүйд итгэх) “итгэлийнхэн” буюу “итгэлийн хүн Абрахамын хамт ерөөгдсөн” итгэгчид билээ (Галат 3). Үндэстнүүдийн одоогийн хүндэт байр суурь нь үнэн хэрэгтээ итгэгчдээс шалтгаалах юм.



Үндэстнүүдийн дундаас дуудагдан, зөвтгөгдөн, алдаршуулагдахаар урьдаас тогтоогдсон хэд хэдэн хувь хүмүүс нь одоогийн байдлаар “зэрлэг мөчир”-ийг Ертөнцийн Эзэний “хатуурхлыг” үзэн, “таслагдах”-аас хамгаалж, ивээлийн “модонд” залгаастай байлгадаг юм байна. Цөөн хэдэн хүн Паулын сайн мэдээнд итгэж Ертөнцийн Эзэнтэй эвлэрэлдсэний ачаар л үндэстнүүд одоогийн давуу эрхт байр сууриа хадгалж байна.



Паулын
зарласан
сайн мэдээ:

“Та нарт тунхагласан **сайн мэдээгээ** би та нарт мэдүүлье. Та нар түүнийг хүлээн аваад түүн дотроо зогссон. Хэрэв миний тунхагласан үгийг та нар баримталбал, **дэмий хоосон итгээгүй л бол**, та нар **түүгээр ч мөн аврагдсан...** Энэ бол **хамгийн чухал** хэрэг байлаа. **Судрын дагуу Христ бидний нүглийн төлөө үхсэн бөгөөд оршуулагдан, Судрын дагуу гурав дахь өдөртөө амилуулагджээ...**”
(1 Коринт 15:1-4)

Гэтэл энэ байдал мөнхөд үргэлжлэхгүйг бид олж харлаа. Энэ ивээлийн хугацаа хэзээ төгсөх вэ гэвэл, Паулын 1 Тесалоник 4:13-17-д зөгнөсөн тэр өдөр. Христ Өөрийн Биеэ энэ дэлхийгээс шүүрэн авч агаар мандалд уулзах өдөрт үндэстнүүдийг таримал модонд залгаастай байлгадаг байсан тэрхүү итгэл энэ дэлхийг орхино. Тэр мөчийг Паул Ром 11-т мөн дурдсан.
Тухайлбал:

“Ах дүү нар аа! Та нарыг өөрсдийнхөө бодлоор мэргэн болчих вий гэсэндээ энэ нууцыг та нар мэдэлгүй өнгөрөхийг би хүсэхгүй байна. Харь үндэстнүүд дүүрэн орох хүртэл Израилийн хэсэг хатуу сэтгэлтэй болсон нь энэхүү нууц билээ. Ийнхүү бүх Израиль аврагдах болно...”
(Ром 11:25-26; АБ2004).



“Үндэстнүүд дүүрэн орох” буюу “бүрэн дүүрэн болох”, “дутуу юмгүй гүйцэд болох” гэдэг нь Их Эзэний Паулаар дамжуулсан сайн мэдээнд итгэхээр товлогдсон хүний тоо толгой гүйцээгдэхийг хэлнэ. АБ2019 энэ хэллэгийг “орж гүйцэх хүртэл” (буюу тайлбарт нь: “харийнхны тоо гүйцэх хүртэл”) гэж зөв орчуулсан байна. Сүүлчийн гишүүн нь итгэх тэр өдөр Христийн Бие гүйцэд болно. Энэ өдрийг Их Эзэн тэсэн ядан хүлээж байна.

Христ Биеэ тэнгэр өөд шүүрч авах тэр мөчөөс эхлэн Паулын тунхагласан сайн мэдээнд итгэдэг нэг ч хүн энэ дэлхий дээр байхаа болино. Тэр өдөр өнөө “зэрлэг мөчир чидун модноос таслагдах болно”. Үндэстнүүд Ертөнцийн Эзэний ивээлийг шууд хүртэхээ болино, Түүний үгийн гэрлийг энэ дэлхийд түгээхээ ч болино гэсэн үг.

Нөгөө талаар Ертөнцийн Эзэний дуудлага “буцалтгүй” учраас Израил үндэстэн “хорвоогийн гэрэл” байх дуудлагаа хэзээ нэгэн цагт заавал биелүүлэх ёстой (Ром 11:29). Тийм ч учраас Үгийг нь түгээх хүндэт үүргийг Ертөнцийн Эзэн цаг нь ирэхээр үндэстнүүдээс авч, эргээд Израилд өгөх болно. Их Эзэн “зэрлэг мөчир”-ийг тасалж, оронд нь “төрөлх мөчрүүд”-ийг өөрийн модонд эргээд залгах нь тийм учиртай.





Тэр үед “Израилын хэсэг хатуу сэтгэлтэй” байхаа болих агаад Их Эзэн хамаг Израилийг аврах болно. Тэд эргээд өвөг эцгүүдэд өгсөн амлалтаас урсах ивээлийн “шим шүүс”-ээр амьдарна. Энэ нь дэлхийд бүр ч их ашиг тус өгөх болно. “Тэдний дүүрэл ямар агуу их байх бол?... Тэдний хүлээн авалт нь үхэгсдээс амилах адил бус уу?” (12,15-р иш). Израилын сэргэлтийн хамт хамаг дэлхий шинэчлэн цэцэглэхэд хүрч, мянган жилийн шударга ёсны Хаант улс байгуулагдах болно. “Хорвоогийн гэрэл” байх дуудлагаа израилчууд бүрэн биелүүлж, Ертөнцийн Эзэний ивээлийг бүх үндэстнүүдэд түгээх болно.

Дүгнэлт: Чидун модны нууцыг мэдэх нь чухал

Бичвэрийг бичвэрүүдээр тайлах зарчмыг дагахаар Их Эзэний бүх үг эвлүүлэх тоглоом шиг хоорондоо таарна. Дээрх тайлал Паулын бичсэн бусад үгтэй сайн эвсэлдэнэ. Бусад зарлагуудын бичсэн зөгнөлтэй ч нийцнэ. Бичвэрүүдэд хувь итгэгч нарт хандаж бичсэн үгийг, бүхэл бүтэн үндэстний хэмжээнд бичсэн үгтэй хольж хутгалдахгүй байх зарчмыг ч дагах нь чухал.

“Израилын хэсэг хатуу сэтгэлтэй болсон нь” хугацаатай, Их Эзэн Израилд өгсөн дуудлагаа заавал израилчуудаар биелүүлэх цаг ирнэ. Энэ нууцыг бид “мэдэлгүй өнгөрөх”-ийг Их Эзэн хүсэхгүй. Тэр цаг иртэл бүх үндэстнүүд Ертөнцийн Эзэний Үгийн ивээлийг шууд хүртэн авч, тэр Үгийг цааш дамжуулах эрхтэй.





Христийн Биеийн гишүүд бид энэ дэлхийд байхдаа тэр эрхийг нь нэг ёсондоо дэмжин хамгаалж байна. Үүнийг ойлгосон бид авралынхаа тухайд санаа амар байгаад зогсохгүй, бүхий л сэтгэлээр баясан хөөрөх болно. “Чидун модноос таслагдах”-аас айх ямар ч шалтгаан бидэнд байхгүй. Тэгэж айж явах нь харин ч Их Эзэний өөрт чинь хандан бичүүлсэн тов тодорхой үгэнд итгэхгүй байх явдал юм. 1000 хувь найдвартай Түүнд итгээрэй!

Ая,
Бурханы мэргэн ухаан болон
мэдлэгийн баялаг нь юутай гүн вэ!
Түүний шүүлтүүд нь ямар ойлгож баршгүй,
Түүний замууд нь ямар олж илрүүлшгүй вэ?
Эзэний оюун ухааныг хэн мэдсэн бэ?
Хэн Түүний зөвлөгч нь болсон бэ?
Хэн өөртөө эргүүлж төлүүлэхээр
Түүнд урьдчилж өгсөн бэ?
Учир нь Түүнээс, Түүгээр,
Түүнд бүх юм байна.

Түүнд
алдар нь
үүрд
байх
болтугай.

Амен.

(Ром 11:33-36)





Ашигласан эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Шинэ гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Хуучин гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org